



From
the People of Japan

Хүний Нөөцийн Хөгжлийг Дэмжих JDS Тэтгэлэгт Хөтөлбөр
Japanese Grant Aid for Human Resource
Development Scholarship Program 2016-2017



Япон улсын тэтгэлгээр 18 оюутан суралцуулна !

Монгол Улсын Засгийн газар нь Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөр” (<http://jds-scholarship.org/>)-ийг 2001 оноос хэрэгжүүлж байна.

Хүний Нөөцийн Хөгжлийг Дэмжих JDS Тэтгэлэгт Хөтөлбөр (цаашид тус төсөл гэнэ) -ийн зорилго нь “Нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөний бодлого боловсруулалт, түүний хэрэгжилтэнд гар бие оролцож, ирээдүйд эх орноо удирдан жолоодохуйц **залуу төрийн албан хаагчдыг** бэлтгэж, Монгол улсын хүний нөөцийн хөгжлийг дэмжих”-эд оршино.

Энэхүү хөтөлбөрөөр Япон Улсын нэр хүндтэй их сургуулиудын магистрантурт англи хэл дээр 2 жил суралцах нийт 18 тэтгэлэгт оюутныг сонгон шалгаруулах ба тэнцэгчид 2016 оны зун суралцахаар явах болно.

1) JDS ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ

JDS хөтөлбөрийн оюутнуудад сургалтын төлбөр болон бусад шаардлагатай сургалтын хураамж, сар бүрийн байр / амьжиргааны зардал, эрүүл мэндийн даатгал, хоёр талын онгоцны зардал, бусад тэтгэмж (Японд анх очиход олгох тэтгэмж, сургалтын материал худалдан авах тэтгэмж гэх мэт) олгогддог. Мөн суралцах хугацаанд нь хичээл сурлага болон амьдрал ахуйд нь тулгамдаж буй асуудал гарвал байнга зөвлөгөө өгч дэмждэг.

2) БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Нас: 2016.4.1-ний байдлаар 22-39 настай байх. (1976.4.2-ноос 1994.4.1-ний хооронд төрсөн байх)
2. Боловсрол: Бакалаврын зэрэгтэй байх. (Монгол Улсын Засгийн газар болон бусад гадаад орны Засгийн газраас албан ёсоор магадлан итгэмжилсэн сургуулийг дүүргэсэн байх)
3. Ажлын туршлага: Хамрагдах байгууллагын үндсэн албан хаагч байх шаардлагатай. Бүртгэлийн сүүлийн хугацаа буюу 2015.10.16-ний байдлаар бакалаврын зэрэг горилсноосоо хойш тухайн элсэх чиглэлээр 2-оос дээш жил тарийн албанд ажилласан байх (Их сургууль төгсөхөөс өмнөх ажилласан хугацаа болон гэрээт ажил, ажлаас чөлөөлөгдсөн хугацаа хамаарахгүй).
4. Төгсөгч нь Япон Улсад суралцсан чиглэлийнхээ дагуу төрийн албанд 2-оос дээш жил тогтвортой ажиллах үүрэгтэй ба суралцахаасаа өмнө энэ тухай тэмдэглэсэн тангаргийн бичгийг Удирдах зөвлөлд илгээх шаардлагатай.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах цахим хуудас (өргөдөлийн маягыг татах):

<http://jds-scholarship.org/>

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2015 оны 10-р сарын 16-ны өдөр

3) БҮРТГЭЛД ХАМРАГДАХ

1. “Нэр дэвшигчдэд зориулсан удирдамж”-ийг харъяа байгууллагынхаа Төрийн захиргаа, удирдлагын газар, Хүний нөөцийн албаас болон JICE JDS Монгол дахь Төлөөлөгчийн Газраас авна уу. Мөн JICE JDS хөтөлбөрийн цахим хаяг <http://jds-scholarship.org/> -аас бүртгэлийн татаж авах боломжтой.
2. Нэр дэвшигчдэд зориулсан танилцуулга семинарыг 9-р сарын 14, 16, 18-ны өдрүүдэд 11:00-12:30 ба 14:00-15:30 цагуудаас тус тус зохион байгуулна. Мөн хамрагдах байгууллагуудын хүсэлтээр тухай байгууллага дээр очиж зохион байгуулах боломжтойгоос гадна нэр дэвшигчдэд оффис дээрээ зөвлөгөө өгөх боломжтой.
3. Өргөдлийн маягыг бөглөн, бусад шаардлагатай бичиг баримтуудын хамт JICE JDS Монгол дахь Төлөөлөгчийн Газар өөрийн биеэр авч ирнэ үү.

4) JDS ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын хөгжлийн асуудал дээр тулгуурлан бүрэлдэхүүн хэсгүүд (чиглэлүүд)-ийг тогтоосон бөгөөд үүнтэй нягт уялдаа холбоотой байгууллагуудыг төсөлд хамруулахаар Монгол Улсын Засгийн газар болон Япон Улсын Засгийн газрын төлөөллөөс бүрдэх Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Иймд хамрагдах байгууллагаас элсэгчдийг нэр дэвшүүлснээр хөтөлбөрт хамрагдах эрх нь нээгдэх ба нэг нэр дэвшигч зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэгт бүртгүүлнэ.

Жич: Хөтөлбөрийн хамрах хүрээнд заасан байгууллагуудын харъяа байгууллагууд хамрагдах боломжтой тул дээд байгууллагадаа хандана уу.

Дэд хөтөлбөр (JDS хөтөлбөрийн тусламжийн тэргүүлэх чиглэл)	Бүрэлдэхүүн хэсэг (JDS хөтөлбөрийн хөгжлийн асуудлууд)		Хүлээн авах хүний тоо	Хэрэгцээ шаардлага (Судалгааны сэдэв)	Хамрагдах Байгууллагууд	Хүлээн авах их сургууль Тэнхим
1. Уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, засаг захиргааг бэхжүүлэх Sustainable development of the mining sector and enhancement of governance	1-1 Байгаль орчинд ээлтэй эрдэс баялгийн менежмент	1-1-1 Байгаль орчны менежмент (удирдлага) Environmental Management	2	Судалгааны чиглэл: Уул уурхайн хөгжлийн улмаас үүсэх байгаль орчны бохирдлоос хамгаалах бодлого, хүрээлэн буй орчны бодлого зохицуулалт (Уул уурхайн хөгжилтэй холбогдон хүрээлэн буй орчныг хамгаалах бодлого болон мониторинг), уг салбарын хүний нөөцийг хөгжүүлэх	Ерөнхийлөгчийн тамгын газар, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Хууль зүйн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа: Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны академийн харьяа: Газарзүй, гео-экологийн хүрээлэн, Хими, хими технологийн хүрээлэн	Кэйюгийн их сургууль Төрийн бодлого, хэвлэл мэдээлэл судлалын тэнхим
		Environment-friendly Mineral Resource Management	2	Судалгааны чиглэл: Эрдэс баялгийг боловсруулах технологи, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх технологи, хайгуулын геофизик	Ерөнхийлөгчийн тамгын газар, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Эрчим хүчний яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа: Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Шинжлэх ухааны академийн харьяа: Хими, хими технологийн хүрээлэн, Газарзүй, гео-экологийн хүрээлэн	Кюшүгийн их сургууль 1) Инженерчлэлийн тэнхим (Байгалийн нөөц баялгийн хөгжил) 2) Дэлхийн нийгэм судлалын тэнхим
	1-2 Санхүү, эдийн засгийн бодлогын менежмент Fiscal Policy Management	2	Судалгааны чиглэл: Татварын тогтолцоо, олон нийтийн хөрөнгө оруулалтын бодлого, санхүүгийн бодлого	Ерөнхийлөгчийн тамгын газар, Сангийн яам, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам (Монгол улсын хөгжлийн банк, Монголын хөрөнгийн бирж орно), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монголбанк	Олон Улсын Их Сургууль Олон улсын харилцааны тэнхим	
	1-3 Хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах Improvement of Legal System	2	Судалгааны чиглэл: Хууль эрх зүйн тогтолцоо, хяналтын тогтолцоо	Ерөнхийлөгчийн тамгын газар, Хууль зүйн яам, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хөдөлмөрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам (Монгол улсын хөгжлийн банк, Монголын хөрөнгийн бирж орно), Улсын их хурлын тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Санхүүгийн Зохицуулах Хороо, Улсын прокуратурын ерөнхий газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Нийслэлийн тамгын газар, Монголбанк, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа: Монгол улсын их сургууль	Кюшүгийн Их Сургууль Хууль эрх зүйн тэнхим	
2. Бүх нийтэд хүртээлтэй хөгжлийн хэрэгжилтэнд чиглэсэн тусламж Assisting Inclusive Growth	2-1 Бизнес эрхлэх орчныг сайжруулах Business Environment Development	3	Судалгааны чиглэл: Төрийн ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, идэвхжүүлэх (сургах), хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх	Ерөнхийлөгчийн тамгын газар, Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Сангийн яам, Эрчим хүчний яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам (Монгол улсын хөгжлийн банк, Монголын хөрөнгийн бирж орно), Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Монголбанк	Олон Улсын Их Сургууль Олон улсын менежментийн тэнхим	
	2-2 Олон нийтийн бодлого боловсруулалт (төрийн захиргаа) Public Administration	3	Судалгааны чиглэл: Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах удирдлага (боловсон хүчний бэлтгэл хамрагдана), нийгмийн хэлмхийн удирдлага, нийгмийн батаалгааны удирдлага, боловсролын бодлого	Ерөнхийлөгчийн тамгын газар, Эрүүл мэнд, спортын яам, Хөдөлмөрийн яам, Хууль зүйн яам, Уул уурхайн яам (Геологийн төв лаборатори орно), Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (Монгол улсын их сургууль, Монгол улсын боловсролын их сургууль, Монгол улсын анагаахын шинжлэх ухааны их сургууль орно), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Мэйжигийн Их Сургууль Засаг захиргааны тэнхим	
3. Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн тусламж Enhancement of the capacity and function of Ulaanbaatar as urban center	3-1 Хотын хөгжлийн инженерчлэл Urban Development Engineering	2	Судалгааны чиглэл: Тээврийн инженерчлэл, хотын инженерчлэл, нийтийн эрүүл ахуйн инженерчлэл	Ерөнхийлөгчийн тамгын газар, Зам тээврийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа: Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол улсын их сургууль	Хиросимагийн Их Сургууль Олон улсын хөгжил, хамтын ажиллагааны тэнхим	
	3-2 Хотын хүрээлэн буй орчныг сайжруулах бодлого боловсруулалт Improvement of Urban Environment Policy	2	Судалгааны чиглэл: Хотын хүрээлэн буй орчны бодлого боловсруулалт, Хүрээлэн буй орчны үнэлгээ	Ерөнхийлөгчийн тамгын газар, Зам тээврийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа: Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны академийн харьяа: Хими, хими технологийн хүрээлэн, Газарзүй, гео-экологийн хүрээлэн	Цүкүбагийн Их Сургууль Амьд байгаль, хүрээлэн буй орчин судлалын тэнхим	
Нийт			18			

5) ЛАВЛАХ ХАЯГ:

JICE JDS Монгол дахь Төлөөлөгчийн Газар (Материал хүлээж авах цаг: Даваа - Баасан, 9:00-12:30, 14:00-17:30)

Хаяг: Монгол-Япон Төвийн байр, 201 тоот, Их сургуулийн гудамж, Төв Ш/Х 917, Улаанбаатар 13

Цахим шуудан: jds@jice.mn

Утас: 976-11-327052, 976-11-326815